



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Татварын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/009/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудитор орлогч Я.Самбууням Утас: 261665 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.ЧИМИДСҮРЭН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/1204
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газар, Сангийн яамнаас Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлсэн 3709-МОН "Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл"-ийн хүрээнд бий болсон нийт 6.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Татварын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 13,833.6 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас 14,327.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 103.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хураалт нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Татварын ерөнхий газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГ



Я.САМБУУНЯМ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,371,802.5	4,520,380.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,784,193.6	1,663,297.4
33	АВЛАГА	633,572.7	712,176.8
34	УРЬДЧИЛГАА	2,483.3	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,951,552.9	2,144,906.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	53,071,623.9	60,200,440.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,071,623.9	60,200,440.7
39200	Биет хөрөнгө	47,389,361.2	49,719,148.8
39300	Биет бус хөрөнгө	5,682,262.7	10,481,291.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	57,443,426.4	64,720,821.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,658,644.9	556,443.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,658,644.9	556,443.8
41300	Өглөг	1,375,622.2	448,691.7
41400	Урьдчилж орсон орлого	283,022.7	107,752.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	55,784,781.5	64,164,377.2
51	Засгийн газрын хувь оролцоо	55,784,781.5	64,164,377.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	20,015,564.2	20,015,564.2
51200	Хуримтлагдсан үр дүн	31,601,339.8	39,980,935.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,167,877.5	4,167,877.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	57,443,426.4	64,720,821.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	88,385,227.8	124,212,386.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,081,790.4	13,275,130.5
120	Нийтлэг татварын бус орлого	9,081,790.4	13,275,130.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,303,437.4	110,937,256.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	90,509,618.5	115,836,764.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	89,361,714.8	115,263,013.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,012,232.1	107,899,967.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,579,109.9	69,535,253.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,184,404.9	8,766,516.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,088,505.2	2,271,500.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,659,350.2	1,900,504.9
2105	Нормативт зардал	45,614.7	18,654.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	588,297.9	524,025.6
2107	Томилолт, зочны зардал	244,863.6	675,073.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,369,275.0	12,393,812.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,252,810.6	11,814,627.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,349,482.7	7,363,045.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,147,903.7	573,750.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(2,124,390.7)	8,375,622.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	973,096.3	2,698.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(3,097,487.0)	8,372,923.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,884,918.8	-	58,884,918.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,650.4)	-	(2,650.4)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,882,268.5	-	58,882,268.5
9	Тайлант үеийн үр дүн	(3,097,487.0)	-	(3,097,487.0)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	55,784,781.5	-	55,784,781.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,671.9	-	6,671.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	55,791,453.4	-	55,791,453.4
19	Тайлант үеийн үр дүн	8,372,923.8	-	8,372,923.8
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,164,377.2	-	64,164,377.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	484,625,365.4	589,207,994.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,541,237.9	6,427,367.7
120	Нийтлэг татварын бус орлого	6,541,237.9	6,427,367.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	478,084,127.5	582,780,626.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	478,428,638.4	577,228,472.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	478,428,638.4	577,228,472.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,881,355.9	97,586,762.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,742,230.8	69,714,804.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,111,986.2	8,674,862.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,088,883.9	2,271,200.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,256,335.6	1,703,834.1
2105	Нормативт зардал	1,294.7	578.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	619,254.6	630,178.3
2107	Томилолт, зочны зардал	193,633.4	627,039.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,293,712.6	12,258,399.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,574,024.1	1,705,866.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	408,547,282.5	479,641,710.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,196,727.0	11,979,522.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,835,010.6	12,100,418.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,835,010.6	12,100,418.7
2200	Дотоод эх үүсвэрээр	4,835,010.6	12,100,418.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,835,010.6)	(12,100,418.7)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,361,716.4	(120,896.2)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	422,477.2	1,784,193.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,784,193.6	1,663,297.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,099,117,000.00	107,189,371,643.49	1,909,745,356.51	98.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,508,313,000.00	103,598,567,643.49	1,909,745,356.51	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,275,697,800.00	98,790,420,460.08	1,485,277,339.92	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	68,511,306,600.00	67,708,883,715.87	802,422,884.13	98.8
210101	Үндсэн цалин	30,414,480,600.00	30,889,305,704.28	(474,825,104.28)	101.6
210102	Нэмэгдэл	15,995,020,600.00	15,568,161,875.54	426,858,724.46	97.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,371,809,000.00	4,186,202,947.57	185,606,052.43	95.8
210104	Урамшуулал	17,729,996,400.00	17,065,213,188.48	664,783,211.52	96.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,766,051,100.00	8,417,201,881.50	348,849,218.50	96.0
210201	Тэтгэврийн даатгал	6,036,585,700.00	5,782,448,777.93	254,136,922.07	95.8
210202	Тэтгэмжийн даатгал	682,366,700.00	669,441,793.31	12,924,906.69	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	341,182,700.00	333,951,772.51	7,230,927.49	97.9
210204	Ажилгүйдлийн даатгал	341,182,700.00	325,508,726.42	15,673,973.58	95.4
210205	Эрүүл мэндийн даатгал	1,364,733,300.00	1,305,850,811.33	58,882,488.67	95.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,356,442,200.00	2,271,200,316.20	85,241,883.80	96.4
210301	Гэрэл, цахилгаан	300,363,700.00	284,598,243.88	15,765,456.12	94.8
210302	Түлш, халаалт	882,547,100.00	841,078,648.72	41,468,451.28	95.3
210303	Цэвэр, бохир ус	119,852,800.00	93,273,375.60	26,579,424.40	77.8
210304	Байрны түрээс	1,053,678,600.00	1,052,250,048.00	1,428,552.00	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,096,075,000.00	1,050,973,004.78	45,101,995.22	95.9
210401	Бичиг хэрэг	272,882,500.00	268,646,827.00	4,235,673.00	98.4
210402	Тээвэр, шатахуун	252,205,000.00	241,483,193.40	10,721,806.60	95.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	270,870,000.00	251,958,772.38	18,911,227.62	93.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,881,400.00	16,425,400.00	456,000.00	97.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	283,236,100.00	272,458,812.00	10,777,288.00	96.2
2105	Нормативт зардал	578,200.00	578,150.00	50.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	578,200.00	578,150.00	50.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	664,085,200.00	658,566,160.91	5,519,039.09	99.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	107,268,500.00	106,512,168.00	756,332.00	99.3
210602	Тавилга	23,659,100.00	23,639,100.00	20,000.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,282,700.00	17,402,800.00	879,900.00	95.2
210604	Урсгал засвар	514,874,900.00	511,012,092.91	3,862,807.09	99.2
2107	Томилолт, зочны зардал	665,585,300.00	608,228,225.00	57,357,075.00	91.4
210702	Дотоод албан томилолт	665,585,300.00	608,228,225.00	57,357,075.00	91.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,732,527,800.00	17,613,365,974.42	119,161,825.58	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,335,735,800.00	5,218,324,721.37	117,411,078.63	97.8

Татварын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,022,000.00	5,022,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	19,816,200.00	19,314,872.00	501,328.00	97.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,528,300.00	4,372,659.00	155,641.00	96.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,291,000.00	1,119,000.00	172,000.00	86.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,071,996,000.00	7,071,995,981.05	18.95	100.0
210807	Газрын төлбөр	7,933,000.00	7,011,241.00	921,759.00	88.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,286,205,500.00	5,286,205,500.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	483,046,400.00	461,423,031.40	21,623,368.60	95.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	94,656,200.00	75,097,860.00	19,558,340.00	79.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	388,390,200.00	386,325,171.40	2,065,028.60	99.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,232,615,200.00	4,808,147,183.41	424,468,016.59	91.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,232,615,200.00	4,808,147,183.41	424,468,016.59	91.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	400,700,000.00	390,823,000.00	9,877,000.00	97.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,367,980,700.00	1,073,572,270.72	294,408,429.28	78.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,179,101,200.00	3,145,395,372.69	33,705,827.31	98.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	284,833,300.00	198,356,540.00	86,476,760.00	69.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,590,804,000.00	3,590,804,000.00	-	100.0
220001	Барилга байгууламж	3,590,804,000.00	3,590,804,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	109,099,117,000.00	107,189,371,643.49	1,909,745,356.51	98.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	104,127,175,000.00	102,138,015,199.13	1,989,159,800.87	98.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	104,127,175,000.00	102,138,015,199.13	1,989,159,800.87	98.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,971,942,000.00	5,051,356,444.36	(79,414,444.36)	101.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,971,942,000.00	5,051,356,444.36	(79,414,444.36)	101.6
4	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсий үлдэгдэл	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	33	33	-	100.0
610001	Төсвийн байгууллага	33	33	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,834	1,810	24	98.7
620001	Удирдах ажилтан	51	51	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1,644	1,628	16	99.0
620003	Үйлчлэх ажилтан	139	131	8	94.2

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,358,263,257.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,328,263,257.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,903,108,874.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,004,750,808.50
210101	Үндсэн цалин		126,438,873.31
210102	Нэмэгдэл		1,565,675,247.99
210104	Урамшуулал		225,225,108.09
210105	Гэрээт ажлын хөлс		87,411,579.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		257,660,133.11
210201	Тэтгэврийн даатгал		206,130,142.99
210202	Тэтгэмжийн даатгал		12,145,537.56
210203	ҮОМШӨ-ний даатгал		6,539,532.55
210204	Ажилгүйдлийн даатгал		5,513,071.98
210205	Эрүүл мэндийн даатгал		27,331,848.03
2104	Хангамж, бараа материалын зардал		675,594,755.31
210401	Бичиг хэрэг		333,401,220.00
210402	Тээвэр, шатахуун		191,136,635.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		48,428,280.31
210404	Ном, хэвлэл		23,971,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		78,657,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		144,347,460.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		60,077,210.00
210602	Тавилга		6,080,990.00
210604	Урсгал засвар		78,189,260.00
2107	Томиллолт, зочны зардал		18,811,000.00
210701	Гадаад албан томилолт		-
210702	Дотоод албан томилолт		18,811,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,729,279,458.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,034,807,078.00
210803	Даатгалын үйлчилгээ		195,940.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		48,400,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		645,854,440.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,072,665,259.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		426,100,103.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		646,565,156.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,425,154,383.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		624,997,977.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		79,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		545,497,977.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		800,156,406.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		24,123,244.63
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		770,462,035.67
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		5,571,125.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		30,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		30,000,000.00
223001	Бусад хөрөнгө		30,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		7,358,263,257.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		7,358,263,257.72

Татварын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,617,183,163.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,533,329,473.63
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,207,750,621.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Татварын албанд нийт 8,103.3 сая төгрөгийн 40 алдаа илэрснээс аудитын явцад 8,103.3 сая төгрөгийн 39 алдааг залруулж, 1 алдаанд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,157.4 сая төгрөгийн 70 зөрчил² илэрснээс, 77.3 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 715.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 33 албан шаардлага, 315.2 сая төгрөгийн 24 зөвлөмж өгч, 49.8 сая төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 1,157.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 33 байгууллагын тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллагыг түүврийн аудитад хамруулж, 24 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргасан. Аудитаар “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт 22 байгууллагад өгч, 2 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

3.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Тайлант онд Татварын ерөнхий газрын харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,103.3 сая төгрөгийн 39 алдаа, 1,157.4 сая төгрөгийн 71 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 3,872.5 сая төгрөгийн 43 зөрчил илэрсэн. Үүнээс санхүүгийн тайланд илэрсэн зөрчил нь өмнөх оноос 422.9 сая төгрөгөөр өсөж, өмнөх аудитаар харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, гаргасан алдаа, зөрчлийг бууруулж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-т "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг 60.0-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Түүврийн байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн зөрчилтэй асуудал

3.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Татварын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад сар бүр 30 хувийн нэмэгдэл, ISO9001:2015 чанарын менежментийг сайжруулах ажлын хэсгийн нарийн бичигт сар бүр үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл олгодог боловч жилийн эцэст төрийн албаны зөвлөлийн нарийн бичгийн даргад сарын цалингийн 40.0 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал, ISO9001:2015 чанарын менежментийг сайжруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргад мөнгөн шагнал өгч үр дүн, урамшууллыг нийт 0.9 сая төгрөгөөр давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.”, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3.1-д “Цалин хөлс, урамшуулалтай холбоотой зардал:1/Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргад албан тушаалынх нь сарын цалингийн тодорхой хувиар үндсэн байгууллагаас нь олгохоор Төрийн албаны зөвлөлөөс тогтоосон урамшуулал,” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2. Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн барилгын 2014 онд үүссэн 5.1 сая төгрөгийн барьцааны үлдэгдлийг чөлөөлөөгүй, аж ахуйн нэгжтэй тооцоо нийлж акт үйлдэх боломжгүй нөхцөл байдалд хүрсэн байна.

Энэ нь Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хугацааг сунгах мэдэгдлийг гаргаагүй бол цахим мэдээллийн санд бүртгүүлснээс хойш гурван жилийн хугацаанд барьцааны мэдэгдлийн бүртгэл хүчинтэй байна.”, 41.3-т “Барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хугацаа дуусахад тухайн барьцааг сунгах мэдэгдэл бүртгүүлэхээс бусад аргаар баталгаажуулаагүй бол баталгаажуулаагүй барьцаанд тооцно.”, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5-д “төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Он удаан жил болж хугацаа дууссан, харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй барьцааны үлдэгдлийг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Том татварын төлөгчийн газар нь дотоод албан томилолтын төсвийг тооцохдоо Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан “Жишиг норм батлах тухай” 390 дүгээр тушаалын дагуу шатахуун зарцуулалтын нормыг баримталдаггүй, томилолтын ажлын нийт км-ыг үндэслэлгүй тогтоосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.2.3 Зөвлөмж

Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт 1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж "Амнат эрдэс баялгийн салбарт өгөгдөл мэдээ дүн шинжилгээ хийх" ажлын 101.4 сая төгрөгийн мэдээлэл технологийн үйлчилгээний зардлын нийт дүнгээс 42.0 сая төгрөгийг шуудан холбоо, интернэтийн зардлаас санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгссөн зөвлөмж: Баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрлөөр холбогдох зардалд эрх тавиулсан зардлыг санхүүжүүлж байх.

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар нийт 3,872.5 сая төгрөгийн 43 зөрчил илэрснээс 373.5 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 3,499.0 сая төгрөгийн зөрчилд 30 зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Түүврийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Байгууллагын албан хаагчид нь татварын байцаагчийн орлогын биелэлтээр сар бүр, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр улирал бүр урамшуулал өгөхдөө үр дүнг бодитоор үнэлээгүй олгож, нэмэлтээр оны эцэст нийт албан хаагчдад үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн урамшууллыг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдын улирлын ажлын үр дүнг үндэслэлтэй, бодитой үнэлээгүй, жилийн эцэст нэмэгдэл, урамшууллыг хавтгайруулан олгосон зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, төсөвт төлөвлөөгүй 48.8 сая төгрөгийн бараа материал, 32.7 сая төгрөгийн хөрөнгө, нийт 81.5 сая төгрөгийн худалдан авалтыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас бэлтгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 48 дугаар зүйлийн 48.2.8-д "энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах;", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төсвийн төсөлд тусгаж төлөвлөөгүй ажил, үйлчилгээг санхүүжүүлж хөрөнгө, бараа, материал бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Тайлант онд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг хуулийн дагуу төсвийн төсөлд бүрэн тусгаж төлөвлөж, тайлагнаагүй, худалдан авах ажиллагаанд зохион байгуулалтын алдаа гаргаж байгаа нь урьдчилан төлөвлөөгүй, шаардлагагүй худалдан авалт хийх, төлөвлөгдсөн худалдан авалтууд хугацаа хоцрох, шаардлага хангахгүй бараа нийлүүлэгдэх улмаар худалдан авалтаас шалтгаалсан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 46 дугаар зүйлийн 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд зохион байгуулалтын алдаа гаргасан зөрчлийг таслан зогсоож, худалдан авах бараа, ажил, үйлчилгээг хэрэгцээ шаардлагад үндэслэн, бодитой төлөвлөх, Үнэлгээний хорооны гишүүдийн чадавхыг сайжруулах замаар зохион байгуулалтын үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг бүрэн тайлагнаж, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.2.1 Зөвлөмж

Илрүүлэлт: Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд эрүүл мэндийн шалтгааны улмаас өөрөө болон гэр бүлийн хүн, аав, ээжийгээ асрах, эмчлүүлэх зэрэгтэй холбоотой албан хаагчид чөлөө олгох асуудлыг нарийн зохицуулаагүйгээс ажилтнууд цалинтай, цалингүй чөлөөлөгдөх асуудал харилцан адилгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд оролцогч дараах суурь зарчмыг баримталж, холбогдох үндсэн эрхийг эдэлнэ", 5.1.1-д "үл ялгаварлан гадуурхах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын дотоод журамд хуульд нийцүүлэн нарийвчилсан зохицуулалт оруулах.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл										Зөвлөмж	
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
II. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ													
1	Багахангай дүүргийн ТХ	1	1,487.3			1	1,487.3	1	1,487.3				
2	Баянгол дүүргийн ТХ	4	17,211.8			4	17,211.8	4	17,211.8				
3	Баянзүрх дүүргийн ТХ	2	3,530,586.4	1	586.4	1	3,530,000.0	2	3,530,586.4				
4	Баянхонгор аймгийн ТХ	2	183,381.5			2	183,381.5	2	183,381.5				
5	Говь-Алтай аймгийн ТХ	2	12,806.1			2	12,806.1	2	12,806.1				
6	Говьсүмбэр аймгийн ТГ	1	11,658.7			1	11,658.7	1	11,658.7				
7	Дархан-Уул аймгийн ТХ	1	190.0	1	190.0	-	-	1	190.0				
8	Дорноговь аймгийн ТХ	4	83,385.3			4	83,385.3	4	83,385.3				
9	Дундговь аймгийн ТХ	3	10,493.0	2	4,456.1	1	6,036.9	3	10,493.0				
10	Налайх дүүргийн ТХ	3	324,295.5			3	324,295.5	3	324,295.5				
11	Нийслэлийн ТГ	3	33,936.1			3	33,936.1	3	33,936.1				
12	Өмнөговь аймгийн ТГ	3	8,701.2			3	8,701.2	2	8,701.2	1	-	1	-
13	Сонгинохайрхан дүүргийн ТХ	3	3,094,732.4	2	3,093,581.4	1	1,151.0	3	3,094,732.4				
14	Сүхбаатар дүүргийн ТХ	4	327,219.1	1	14,082.0	3	313,137.1	4	327,219.1				
15	Төв аймгийн ТХ	2	429,628.9			2	429,628.9	2	429,628.9				
16	Чингэлтэй дүүргийн ТХ	2	33,587.3			2	33,587.3	2	33,587.3				
	Дүн	40	8,103,300.6	7	3,112,895.9	33	4,990,404.7	39	8,103,300.6	1	-	1	-

Татварын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/мянган төгрөг/

Д/Д	Байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл													
		Нийт зөрчил			Үүнээс										
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо	Дүн	Х/тоо	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Х/тоо	Тоо	Дүн		
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
I. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ															
1	Татварын ерөнхий газрын дарга	1	-	-			1	-							
	Дүн	1	-	-			1	-							
II. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ															
1	Архангай аймгийн ТХ	2	3,000.0				2	3,000.0							
2	Багануур дүүргийн ТХ	1	501.6		1	501.6									
3	Багахангай дүүргийн ТХ	1	1,473.8						1	1,473.8					
4	Баянгол дүүргийн ТХ	2	23,900.0				1	23,900.0	1	-					
5	Баянзүрх дүүргийн ТХ	1	24,450.0				1	24,450.0							
6	Баян-Өлгий аймгийн ТХ	2	85,282.4		1	1,000.0	1	84,282.4							
7	Баянхонгор аймгийн ТХ	5	95,266.2		2	687.7	2	6,277.4	1	88,301.1					
8	Говь-Алтай аймгийн ТХ	2	318.2		1	318.2	1	-	-	-					
9	Говьсүмбэр аймгийн ТГ	2	1,366.9				1	596.8	1	770.1					
10	Дархан-Уул аймгийн ТХ	6	82,224.4		2	3,553.6			4	78,670.8					
11	Дорнод аймгийн ТХ	2	81,931.4				1	81,931.4	1	-					
12	Дундговь аймгийн ТХ	2	7,096.1						2	7,096.1	-	-			
13	Завхан аймгийн ТХ	1	67,942.5						1	67,942.5	-	-			
14	Налайх дүүргийн ТХ	2	5,712.0						1	5,195.0	1	517.0			
15	Нийслэлийн ТГ	3	26,520.7						1	19,581.6	2	6,939.1			
16	Орхон аймгийн ТХ	2	20,950.9						1	20,950.9	1	-			
17	Өвөрхангай аймгийн ТХ	2	1,831.0						2	1,831.0					
18	Өмнөговь аймгийн ТГ	10	303,854.9		1	34,510.0	8	219,544.9						1	49,800.0
19	Сонгинохайрхан дүүргийн ТХ	3	48,175.4		2	30,675.4	1	17,500.0							
20	Сүхбаатар аймгийн ТХ	3	45,691.7						2	45,691.7	1	-			
21	Сүхбаатар дүүргийн ТХ	1	18,958.6								1	18,958.6			
22	Сэлэнгэ аймгийн ТГ	1	12,500.0								1	12,500.0			
23	Татварын ерөнхий газар	3	48,145.1		2	6,085.7					1	42,059.4			
24	Том татвар төлөгчийн газар	1	-						1	-					

Татварын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

25	Төв аймгийн ТХ	6	1,190.3			1	1,092.0	5	98.3						
26	Увс аймгийн ТХ	1	22,989.0					1	22,989.0						
27	Ховд аймгийн ТХ	1	84,291.0			1	84,291.0								
28	Чингэлтэй дүүргийн ТХ	1	41,875.9					1	41,875.9						
	Дүн	69	1,157,440.0		12	77,332.2	32	715,154.7	24	315,153.1				1	49,800.0
	НИЙТ ДҮН	70	1,157,440.0		12	77,332.2	32	715,154.7	24	315,153.1				1	49,800.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил			Үүнээс											
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Албан шаардлага /Хариуцлага тооцуулах/			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
					Тоо	Дүн	х/тоо	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Х/тоо	Тоо	Дүн
А	Б	1	2		3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил																
II. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ																
1	Говьсүмбэр аймгийн ТГ	1	45,690.9						1	45,690.9						
2	Дархан-Уул аймгийн ТХ	1	-						1	-						
3	Налайх дүүргийн ТХ	1	56,370.4				1	56,370.4								
4	Өвөрхангай аймгийн ТХ	1	3,186.9						1	3,186.9						
5	Сонгинохайрхан дүүргийн ТХ	1	1,407,417.1						1	1,407,417.1						
6	Сүхбаатар дүүргийн ТХ	2	923,894.2						2	923,894.2						
7	Сэлэнгэ аймгийн ТГ	1	-						1	-						
8	Чингэлтэй дүүргийн ТХ	1	-						1	-						
	Дүн	9	2,436,559.5				1	56,370.4	8	2,380,189.1						
2. Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил																
II. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ																
1	Багануур дүүргийн ТХ	1	5,870.0						1	5,870.0						
2	Багахангай дүүргийн ТХ	2	18,413.3				1	1,348.4	1	17,064.9						
3	Баянгол дүүргийн ТХ	3	258,153.1				1	90,373.6	2	167,779.5						
4	Баянзүрх дүүргийн ТХ	2	80,267.0				2	80,267.0								
5	Говьсүмбэр аймгийн ТГ	2	1,355.8						2	1,355.8						
6	Дундговь аймгийн ТХ	1	2,992.0				1	2,992.0								
7	Налайх дүүргийн ТХ	2	63,482.6						2	63,482.6						
8	Нийслэлийн ТГ	4	346,747.4				1	7,440.0	3	339,307.4						
9	Сонгинохайрхан дүүргийн ТХ	4	165,433.9				1	19,400.0	3	146,033.9						
10	Сүхбаатар дүүргийн ТХ	3	92,027.9						3	92,027.9						

Татварын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

11	Татварын ерөнхий газар	4	81,512.5				3	81,512.5	1	-				
12	Төв аймгийн ТХ	1	14,400.0				1	14,400.0						
13	Хан-Уул дүүргийн ТХ	3	202,072.5						3	202,072.5				
14	Чингэлтэй дүүргийн ТХ	2	103,216.3				1	19,365.6	1	83,850.7				
	Дүн	34	1,435,944.3				12	317,099.1	22	1,118,845.2				
	НИЙТ ДҮН	43	3,872,503.8				13	373,469.5	30	3,499,034.3				